



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 05 сарын 12 өдөр

Дугаар 167 .

Улаанбаатар хот

Зөвлөх баг томилон ажиллуулах
тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгч асан, иргэн Н.Энхбаярын эрүүл мэндийн байдалтай холбогдуулан ТУШААХ нь:


1. Монгол Улсын Ерөнхийлөгч асан, иргэн Н.Энхбаяр хуурай өлсгөлөн зарласантай холбогдуулан эрүүл мэндийн яамнаас ажиллах зөвлөх багийн бүрэлдэхүүн, багийн ажиллах чиглэлийг хавсралтаар баталсугай.
2. Зөвлөх багийн бүрэлдэхүүнд ажиллах мэргэжилтнийг ажлаас нь чөлөөлж, цалин хөлсийг олгох, ажиллах нөхцөл боломжоор хангаж ажиллахыг Улсын клиникийн төв эмнэлэг (Б.Бямбадорж), Шастины төв эмнэлэг (Б.Батчулуун), Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв (Л.Эрдэнэбаяр), Клиникийн 2 – р нэгдсэн эмнэлэг (Г.Баясгалан), Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн (Ж.Оюунбилэг) - д тус тус даалгасугай.
3. Н.Энхбаярын эрүүл мэндийн байдалд үзлэг хийж, хяналт тавих эмч, мэргэжилтний багтай нягт хамтран ажиллахыг зөвлөх багийн ахлагч (Д.Гончигсүрэн) –д, эмч мэргэжилтний багт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа цагдан хорих 461 дүгээр ангийн эмнэлгийн ерөнхий эмч Л.Дамдинсүрэн, их эмч Б.Жавхлантөгөлдөр нарыг тохиролцсоноор ажиллуулахыг багийн ахлагч (Г.Баясгалан) – т тус тус үүрэг болгосугай.
4. Уг тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Н.Түмэндэмбэрэлд даалгасугай.

САЙД

Н.ХҮРЭЛБААТАР



Эрүүл мэндийн сайдын 2012 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 167 тоот тушаалын хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ЗӨВЛӨХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Багийн ахлагч:

Д.Гончигсүрэн - Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Зөвлөх:

Б.Батсэрээдэнэ, Анагаах ухааны доктор, профессор

Нарийн бичгийн дарга:

Ч.Баярмаа - Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Дотрын өвчин судлал:

- 1. Б.Цэрэндаш – Эрүүл мэндийн яамны дотрын мэргэжлийн салбар зөвлөлийн дарга, академич
- 2. Н.Туул – УКТЭ –ийн Гасторэнтерологийн төвийн эрхлэгч, анагаах ухааны доктор
- 3. Д.Чулуунцэцэг – УКТЭ –ийн гемодиализийн төвийн эрхлэгч, клиникийн профессор, тэргүүлэх зэргийн эмч

Сэхээн амьдруулах, амь тэнссэн анагаах ухаан:

- 1. Л.Ганболд - Эрүүл мэндийн яамны сэхээн амьдруулах, амь тэнссэн анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөлийн дарга, анагаах ухааны доктор
- 2. З.Түмэнжаргал – Клиникийн 2-р эмнэлгийн мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч

Зүрх судас судлал

- 1. Д.Нарантуяа - Эрүүл мэндийн яамны дотрын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, анагаах ухааны доктор
- 2. З.Лхагвасүрэн - Шастины төв эмнэлгийн зүрхний эмч, анагаах ухааны доктор, клиникийн профессор

Сэтгэц судлал

О.Ганчулуун – Эрүүл мэндийн яамны сэтгэц судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, клиникийн профессор, тэргүүлэх зэргийн эмч

Мэдрэл судлал

1. Г.Цагаанхүү - Эрүүл мэндийн яамны мэдрэлийн мэргэжлийн салбар зөвлөлийн дарга, академич, анагаах ухааны доктор, профессор
2. Ж.Ариунаа - Эрүүл мэндийн яамны дотрын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Шастины төв эмнэлгийн мэдрэлийн тасгийн эрхлэгч, анагаах ухааны доктор

Хордлого судлал:

С.Юндэн - Эрүүл мэндийн яамны эрүүл ахуй, хор судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, анагаах ухааны доктор, профессор

Уламжлалт анагаах ухаан

Д.Нацагдорж – Эрүүл мэндийн яамны уламжлалт анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, профессор, гэвш, билгүүн номч, хамба лам

ЗӨВЛӨХ БАГИЙН АЖЛЫН ЧИГЛЭЛ:

- Мэргэжлийн үзлэг шинжилгээ хийх, эрүүл мэндийн байдалд дүгнэлт гаргах, зөвлөгөө өгөх
- Эмч, мэргэжилтний баг, төрөлжсөн мэргэжлийн багтай хамтран ажиллах
- Эмчилгээний зөвлөмж, удирдамж гаргах